

МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧ БА БИЛИГ ЕРТӨНЦ

О.Лхагва, профессор, МУИС
Л.Амарболд, Сингапурын Их Сургууль

Abstract

It is getting grow an opinion that comprehension of quantum physics as fundamental science for studying material world is turned out to be close to completion and further it will contribute mainly to promotion of technological progresses. Therefore in future new tendency of natural science would probably be focused on exploring complementary interconnections of material and hidden spiritual realities of the Universe. Here instigating from the recent “exotic” experimental facts and made-up estimations, which are not being interpretable in frame of modern quantum science it is to put forward some intuitive thoughts for explaining the mentioned problem.

In the paper the problem concerning genuine root of proper nomadic science-Munkh Tengery is considered. Newest progresses in quantum physics and synergy have confirmed that the universe represents undividable whole as atom. We are suggesting that the root of Munkh Tengery force is formed by means of intertwining human awareness to the cosmic consciousness or spiritual field force, empowering capabilities to resolve knowing, creating and evolving all material and spiritual realities in the Universe. Thus shaped desires of a person might become primary seed leading to adoption of Blue Eternal Heaven (Munkh Tengery) order for starting creation and evolution of realities. Besides, the question relating nomadic Mongolian progenitors’ proficiencies that are believed to be firmly connected to souls of dead ancestors and able to get from them information and advises on all events connected to nomad’s past and future life.

Түлхүүр үг

Хумхи ертөнц, Ил, далд оршихуйн шүтэн барилдахуй, бие цогцос, сүнс. Байгалийн тулгуур ба Тэнгэрийн сэрэхүйн хүч. Мөнх Тэнгэрийн хүч ба зарлиг.

Удиртгал

Өнө эртнээс их талын нүүдэлчид далд ундаргатай соёл, эрдэм бадрааж, удаа дараа эзэнт гүрэн байгуулсны оньс нь өнөөг хүртэл тайлагдаагүй аж. Өрнийн онч (rational) шинжлэх ухаан учрыг нь олох гэж судлаад “тулгуур” таамнал дэвшүүлсэн нь “хар домог” [1] хочтой болжээ. Нүүдэлчдийн эрдэм бүр өнөөгийн квант физикийн үзэл, номлолын цар хүрээний чинадах “далд” буюу билиг ундаргаас эхтэй учраас түүнийг одоо ч мэдэрч чадахгүй байна хэмээнэм. Энэ бол Орчлонгийн ил хийгээд далд оршихуйн ний шүтэлцлийн үйлээр цогцлох бодист юмс- бие-сэтгэл-тэнгэрийн (билиг) сэрэхүйн зүй тогтлын тулгуур судалгаа [2,3] руу хүмүүний танихуйг хурайлан дуудсаар буй байгаль, нийгмийн ухааны зангилаа асуудал мөн.

Эдүгээ цагийн физикийн үзэл, онолын хүрээ хилийг давсан, тайлал утга нь олдохгүй “сондгой ёр” туршилт мэр сэр тавигдах боллоо. Энэ нь ягшмал хуульд дархлаатай “сонгодог” физикчдийн ой тойнд ер буухгүй байсан XIX, XX зууны зааг дахь сондгой туршилтын “жиг жоготой” баримт сэлтийг [2, А1.7, 8; АП.2; 4] даруй санагдуулна. Тэр үед мөнөөх баримтаар цухуйсан учгаас үүтгэн бүр сонгодог физикийн үзлийн хөрснөөс ангилаг даван зоригтой үсэрч,

“онгон” квант ертөнц рүү нэвтэрсэн түүхтэй. Тэр ертөнц нь гоц өвөрмөц квант хууль жамтай болохыг тогтоосон юм. Квант жамыг нэн товч томьёолбол атом нь хэвийн төлөвтөө бол хэрхэвч үл салах нэгэн цул амь цогцос бөгөөд зүй тогтлыг нь сонгодог эрдмийн хүрээнд илэрхийлэх найдвар огтхон ч үгүй. Харин эвдэлж буталбал электрон, протон, туяа гэх мэтийг цацруулна. XX зуунд тусгаар атом, молекулыг судалж “гаршуулаад” эдүгээ хооронд нь холбож хэлхээд дэлхий ээжид заяагаагүй шинэ төрөл бодис үүсгэх арга-нано технологи [5] хөгжиж байна.

Физикийн шинэхэн туршилтуудаас сэдэж, Орчлон бүхэлдээ үл салах нэгэн амь бөгөөд язгуурт нь тэнгэрийн сэрэхүй (*cosmic consciousness*) буюу аливаа хувьсал, бүтээх, бүрлэхүйн заяаг хөтөлдөг ухаарлын (тэнгэрлэг, бурханлаг!) хүч байна гэх санаа руу чиглэсээр яваагаа энд цэгцлэв. Квант физик, синергетикийн үзэл санаанд суурилуулан, дурдсан жиг туршилтын баримтын учиг дагуулан няргаж судалснаар тайлал нь олдоогүй нүүдэлчдийн амин эрдэм-Мөнх Тэнгэрийн унги үндсийг тэмтрэх зорилтыг өвөрлөн олон жил мэтгэж [2] явна. Өгсүүр бартаа, будант зам дахь хайлтын дүнг шөвгийн нэгэн төвшин рүү дөхүүлснээ толилуулж байна. Өгүүллийн I зүйлд Орчлон, хумхи ертөнцийн салбарт үйлдсэн “жиг”

туршилтын баримтаас товч дурдана. Хоёрдугаар зүйлд *эсийн барилдахуйн мэдээллийн* тухай ярилцана. Гуравдугаар зүйлд скаляр долгио, сүнсний [3] тухай өгүүлнэ. Дөрөвдүгээр зүйлд Тэнгэрийн сэрэхүйн орон болон хүчний тухай шинэ таамнал [3] дэвшүүлнэ. Тавдугаар зүйлд Мөнх Тэнгэрийн хүчний язгуур үндсийг бэдэрсэн санаа таамналыг өгүүлнэ.

Сондгой ёр туршилтууд: Орчлон, хумхи ертөнц

Өнөөгийн сондгой ёр туршилтуудын баримтыг төнхөөд байхад ил бодист юмс, далд билиг сэрэхүйн ний оршихуй нь их Орчлонгийн бүрэлдэх, бүрлэхүйн тавилан заяа буюу “бурханлаг” жамыг л хурайлан хөтөлдөг мэт бодол төрүүлээд байх юм. Тиймээс шинэ үзэл санааны хөврөл рүү хүргэдэг тулгуур-ёр туршилт, түүнээс үрслүүлсэн сэдэл санааг зон олныхоо сонорт хүргэхийг молхи байгальч бээр зориглов.

Орчлон нэгэн амь багцрал. Францын А.Аспектийн эрдмийн гал бодис, юмс дахь нэг бөөмд нь үйлчилж хөндөхөд холбогдох мэдээлэл нь Орчлонгийн нөгөө хязгаарт буй ижил бөөмст эгшин зуур хүрдгийг нотолжээ [6]. Орчлон нэгэн амьд багцармал заяатайг энэ туршилт нотлов. Тэгэхлээр юмс, хүн, амьтсын бие цогцос бол тус тусдаа битүү “тусгаар” юмс огтхон ч бус аж. Орчлон нэл ний оршихуй мөнийг туршилт тэгж тодруулав. Тусгаар юмс байгаа гэх нь унги чанараас нь хэт хийрсэн “ухар” бодол санаан дахь хий томьёолол л аж.

Зууны гэгдэх эл туршилт харьцангуйн ерөнхий онолын тулгуур багана-гэрлийн хурд тогтмол бөгөөд хурдын дээд хязгаар гэдэг тунхаглалыг эрс зөрчив. Орчлонд үйлчлэлийн хурд төгсгөлгүй болохыг тодруулснаар бүх юм тугаар салангид байж үзэгдэх нь далд “шидийг” нь мэдрэхгүй байгаагаас үүдсэн андуу төсөөлөл аж. Өлгөж цэгнэвэл, Орчлон бол яавч үл салах нэгэн амь цогцос мөнийг баталж байна. Нүүдэлчид задгай тэнгэрийн дор эн захад нь үл хүрэм их талд ертөнцийн ил хийгээд далдын догшин хувиралтыг тэсэн туулж амьдрахдаа илийг хүртэхүйдээ тусгаж, далдыг билиг сэрэхүйгээрээ мэдрэх увдис чадлыг олсон байж. Нүүдэлчид билиг эрдмийн хөврөлд чухамдаа тэгж бүр бултаараа хүрсэн байна. Нүүдэлчний амин эрдэм-Мөнх тэнгэр ч тэр билиг хөврөлөөс хүмүүний ой ухаанд исэж дэврээд улмаар далд соёл хөгжүүлээд, эзэнт гүрэн бадраахад хүргэсэн байна. Хүмүүний уураг тархи, эс, ДНХ бол Тэнгэрийн сэрэхүйн жолоодлогоор тасралтгүй хувирч, төгөлдөржихийн сацуу Орчлонгийн билиг ертөнц дэх өнө, өнөө, ирээдүй цагийн мэдээллийг шууд мэдрэх дээд увдис бүхий танихуйн төгс бүтэц-хэрэглүүр юм. Байгалийн

үйл учрал тохиосон болон хүмэнэй хүсэл залбирал дагуу тэнгэрийн сэрэхүйн орны зарлиг шийтгүүлснээр аливааг бүтээх, бүрэлгэх төөрөг хүчийг бүрэлдүүлж болох мэт.

Холограф ба Орчлон. Хаанаас нь ч харсан юмсын бүтэн биежил (3 хэмжээст) дүр зургийг босгодог квант долгиолог зүйд суурилсан арга олоод төхөөргийг нь ч физикчид [7, 2.АПП.7, 8.] хэдийнээ бүтээжээ. Дүрс буулгасан хальсыг нь хэчнээн ч буталж хигсэн мөнөөх бодит дүрс үйрмэг бүрд нь бүрэн хадгалаатай байдаг. Квант физикийн энэ “ад” нээлтийг холограф гэнэ. Физикч Д. Бом, эл хийгээд А.Аспектийн туршилтын баримтыг синергетикийн онолын дүгнэлтээр төлжүүлээд аливаа бодисын өчүүхэн хэлтэрхий (электрон, протон гм) бүр нь Орчлонгийн бүрэн мэдээлэл агуулна хэмээн зөгнөжээ. Цаашлаад Орчлон нэг амь багцрал юм бол бүхлээрээ аугаа холограф [7] бүтэцтэй гэж таамнал дэвшүүлсэн байна. Тэгэхлээр нэг бөөмд ч Орчлонг бүтнээр нь босгох мэдээлэл бүрэн байх юм.


Нейрофизиологч К. Прибрам ч уураг тархины мэдээллийн бүтэц нь холограф төрхтэйг туршилтаар [8] нотлов. Тэрээр сэрэхүй (consciousness) бол Орчлонгийн багцарлын холограф бүтцэд хадгалаатай мэдээллээс үүдэлтэй гэх санаа дэвшүүлжээ. Тэгэхлээр манай уураг тархи, эд эс бүрийн дотоод дахь бүхий л цэгт Орчлонгийн холограф орон няргаж шүглэсэн байх юм. Орчлонгийн холограф бол мөнөөх “хар юм” л байх нь гарцаагүй. Ухаант хүмэн тэр билиг буюу “ухаалаг” далай лугаа ний болохуйд гурван цагийн мэдээллийн далайгаас “ундаалах” заяаг түшдэг хэмээх санааг өмнө дурссаныг саная.

Холограф бол эдүгээ эрдмийн шинэ хөтөч үзэл (paradigm) бүрэлдүүлэх болов. Орчлонгийн нэгэн амь багцлал дахь аливаа үйл, хувирлыг Тэнгэрийн сэрэхүйн (cosmic consciousness) жолоодлогоор өрнөдөг хэмээх хөтөч үзлээс үүтгэн шинжих шаардлагатай болов. Орчлонг тэгэхлээр, их билиг-холограф далайд өрнөх суу зал (synergy)-ийн үйл- хуйлрал хувьсалаар бүхний зуурдын заяаг хөтөлдөг агуу их уураг тархи мэтээр үзэх санааг ч дэвшүүлдэг болов. *Бодлоор хувирлыг хөтлөхүй.* Бодол бөөмсийн туулах замыг өөрчилж байгааг туршилтаар [9,10] нотлов. Тавилан жам бол урьдаас бэлэн зураг төөрөг огтхон ч бус, харин ч хүний мөрөөдөл хүслийг “дуулж” хувирах шидтэй болохыг туршилт харуулав. Ил хийгээд далд оршихуйн шүтэлцээ харьцахуйн жамаар аливаа юмс зуурдын төрх төлөв “шууд” олж бүрэлдэх заяатайг энэ туршилт баталсан. Хүний мөрөөдөл хүсэл бол хумхи оршихуйн хувьд дүлий дүнбэ ч ер биш аж. Харин хүн мөрөөдөл залбирлаараа юмс хувьслын тэнгэрийн хөтлүүр хөврөл үүсгэж, гарц бүтээл-бүрэлдэх, бүрлэхүйн “зарлиг” шийтгүүлэх

шидтэйг эл туршилт илрүүлэв гэвэл зохилтой. Цаашилбал, хүмэн хүсэл зорилгоо тэнгэрийн сэрэхүйн (cosmic consciousness) хүчний оронд хүргэн дуулгаж дарвиулбал (резонанс) илийн чинад лугаа найраад мөрөөдөл хүсэл биелэх шидийг үүсгэдэг мэт байна. Тэгвэл үлгэр, домогт өгүүлдэг шид хүчийг ч хүмүүн эзэмдэж байсныг яахин үгүйсгэнэм билээ дээ. Бас хүмэн өөрөө газрын аминч ахуй-сэтгэлээс салж, билиг эрч хүч лүгээ нийлэхүйд хүсэл, зорилгоо хэрэгжүүлэх зарлиг шийтгүүлэх шидийг олж болохыг физик туршилт ийнхүү сануулж байна. Тэр шид залуур хүчийг хайх нь бас л тулгуур асуудал мөн.

Санаанд үл багтах цэгнэлт. Физикчид бас нэг чухал цэгнэлт хийжээ. Орчлонгийн оршихуйн 96 хувийг [11] эзэлж буй хар юм, хар энерги буюу билиг далайн энергийг үнэлсэн байна. Хар гэсний учир нь ямар ч төсөөлөлгүй, мэдэхгүй байгааг илэрхийлж байгаа хэрэг.

Зураг 1
Орчлонгийн масс-энергийн нягтын бүрдэл. Энд бол байх нөхцөлд тохиох орчлонгийн цухалдах нягт



Өмнөх туршилтуудаас ухвал аливаа юмс, бидний цогцосч Орчлонгийн далдын “хар”-билиг далайд живээстэй байх аж. Орчлон, аливаа юмс, бидний биеийн доторч цэг бүрт мөнөөх билиг далай шүглээтэй аж. Тиймээс маний биеийн массын 96 хувь нь ч бас л далд билиг далайнх аж. Хүмэн бол сэдэж, сэтгэж бүтээх далд шид ундрагтай. Дээрхийн гэгээнтэн Далай багштан матери буюу уураг тархи, эд эсэд оюун ухааныг үүсгэх увидас байхгүй гэсэн нь нэн оносон үг юм.

Өгүүлснийг цэгнэхүйеэ, бидний цогцос аливаа юмс бүгд л гүн чинаддаа далд билиг ертөнц-Мөнх Тэнгэрийг тээж явах аж. Амьгүй юмсаас дээд оюун ухаант хүмүүнийг хүртэл хувьсал эгэлээс дээд оюун ухааныг хүртэл өрнөсөн гэдэгтэй хэн бүхэнд санал нийлнэ биз ээ. Энэ бол Орчлонгийн хувьслын дэгжсэн жам. Бодол санааг бид битүү мэдэрч мэддэггүй лүгээ адил Орчлонгийн хувьсал дээд төвшиндөө мэдрэхүйн эрхтэнд үл өртөх тэнгэрийн сүнслэг ухаарлыг ч хүртэл урлан бүтээсэн байж таарах нээ.

Мөнх Тэнгэр эрдмийн хувьсахуйн “Их суу заль” номлол болон синергетикийн үзэл ёсоор хувьсал бүхнийг хамгийн эгэлээс нь дээд төгөлдөр рүү тэгж өгсүүлэн бүтээж, мэдээллийг хурааж, төгөлдөржүүлж, арвижуулдаг жамтай. Орчлонгийн хувьсал дээд ноён оргилдоо Дээд Тэнгэрийн заяа (мөнхийн сүнс, eternal heaven, вечный дух)-ариун билгийг цэцэглүүлэн бүтээсэн гэх санаа руу туршилтын баримт ийнхүү хөтөлж байна. Товчхондоо оюун ухаант хүмэн та бид Орчлонгийн оройн дээд цэцэг буюу “одон” ажээ.

Квант үнэлгээ. Тодорхойгүйн харьцаа бол квант физик дэх нэг гол тулгуур нь мөн. Эл харьцаа бол тусгаар бодист биеийг мөр мөшгөн тодорхойлдог Ньютоны (determinist) зарчмаас хэрхэвч үл салах амьсгал заяатай багцлалыг (wholeness) илэрхийлэх квант жам руу шилжихэд хэрэглэсэн үнэлгээний ойролцоо томьёо юм.

Зураг 1

$$\Delta p \Delta x \geq \frac{1}{2} \hbar \quad \Delta E \Delta t \geq \frac{1}{2} \hbar \quad p = \frac{h}{\lambda} \rightarrow \lambda = \frac{h}{p}$$

Зураг 1. Бөөмийн импульс, координатын болон энерги, хугацааны завсар дахь (хэмжилтийн алдааны) утгын харгалзсан үржвэр нь $\hbar$ утгаас их буюу тэнцүү байж гэмээж нь мөнөөх систем квант жамаар оршин тогтноно. Квант ертөнцөд бөөм бүр ширхэглэг болон долгиолог төрхийн нэгдэл мөн. Бөөмийн импульс, долгионы урт хоёрын шүтэлцлийг сүүлчийн томьёогоор илэрхийлнэ. Планкийн гэж нэрлэдэг, квант жам хэрэгжихүйн билэг тэмдэг-тогтмол $6.626\,070\,040 \times 10^{-34}$ Жоуль * секунд.

Тодорхойгүйн харьцаа нь орчлонгийн аливаа юмс оршихуй нь бөөмлөг, долгиолог төрхийн шүтэлцэхүйн жамтайг илэрхийлнэ. Тодорхойгүйн харьцаанд тулгуурлан Нобелийн шагналт Р. Фейнман нэг хоосон сияа аяганд дэлхийн далайг буцалгахад хүрэлцэх энерги байгааг үнэлсэн байдаг [2.АIII]. Энэ бол мөнөөх билиг хар далайн энерги мөн нь дамжиггүй. Үнэлгээнд 10^{-35} метр зайн чинад руу бөөмлөг төрх алдарч, хумхи хар нүх (microblack whole) лүгээ хувирна гэж үзсэн байна. Орчлонгийн “хар” юмсын далай тийнхүү яндашгүй энергийн ундраг аж. Сая тэмдэглэснийг сөрж бодохул ширхэглэг чанарын чинадад долгиолог төрх дагнаж таарах аж. Тэгэхлээр бодислог юмсын гүн чинадад ухаарлын нэл далай байх буюу. Тиймээс хар нүхэнд мөнөөх ухаарлын долгиолог төрхөөс үүсдэг холограф зүй тогтол ноёлох болно. Орчлонд

гурван цагийн турш өрнөсөн үйлийн мэдээлэл-энерги холограф “далайд” үелэн хадгалаастай [2.АIII.7] байх нээ. Дашрамд дурдахад их говийн хэрмэн цавын элсэн суваргын үе давхаргууд нь галав галавын хувирлын номын сан мэт сэтгэгдэл төрүүлж байж билээ. Хумхи хар оронд хувьслаар төрөл арилжих хугацаа секундэд явна. Энэ бол хувьсал бүрэн үелэн давтах Планкийн гэгдэх жишиг хугацаа юм. Энерги-мэдээллийн тэрхүү холограф далайд бодист ил хийгээд тэнгэрийн сэрэхүйн хүчний хооронд мэдээллийн шүтэлцэл секундэд төгс шийдвэрт хүргэнэ.

Чинадын чинад тэр билиг ертөнцөд Орчлонгийн алив хувьслыг хөтлөх ухаарал сэрэхүйн жолоо заяасан гэх санаанд хүргэж байна. Синергетикийн үүднээс үзэхэд Орчлонгийн “ухааралд” холограф нь бас фрактал [2.АII.6-8] буюу “баржиг” төрхтэй.

Өөрөөр хэлбэл их нь багыгаа бага нь ихийгээ өвөрлөж багтаасан холограф бүтэц болно. Тэгвэл бодис юмс, ялангуяа Орчлонгийн холографийн өчүүхэн хигээс нь болох хүмэн Орчлонгийн ухаарал сэрэхүйн чадлыг ч бүрэн өвөрлөнө. Хүмэн бол дээд тэнгэрийн заяаг эзэгнэн бүрэлдсэн Орчлонгийн хувьслын оройн цэцэг нь гэх санаа урган гарч байна. Харин бие цогцсын бөөм бүрд мөнөөх хар далай хадгалаатай тул Орчлонгийн бүрэн мэдээллийг хадгална.

Хурдсан тэлж байна. 2011 онд астрофизикчид Орчлон хурдсан тэлж байгааг нотолсон туршилтаар [12] Нобелийн шан хүртэв. Бодист үзэлд суурилуулан босгосон харьцангуйн ерөнхий онол ёсоор бол, их дэлбэрэлтээс инагш тэлж буй Орчлон таталцлын (gravitational) хүчний үйлчлэлээр массыг яваандаа эргээд хумьж хураах номтой. Эрин цагийн физикийн үзэл, онолын хүрээнд хурдсан тэлэхийн учрыг тайлж чадахгүй. Одоохондоо шинжлэх ухааны царааг давсан асуудал мөн. Өмнө өгүүлснийг болгоовол, Орчлонгийн нэгэн амь багцарлын хувьслын оргил нь Тэнгэрийн сэрэхүй юм бол хурдсан тэлэлт юм бол тэр тэлэлт гагцхүү дээд тэнгэрийн “шугаман бус геометр” буюу орны шийдвэр “зарлигаар” бүтэж буй шид үйлс баймаар. Магадгүй нүүдэлч өвөг дээдсийн шүтэж харьцсаар ирсэн Мөнх Тэнгэрийн хүч бол их суу залийн номлолд тийм хувирлыг залуурдах шид буюу хувьслыг хөтлөх зарлиг шийтгэдэг билиг хүчийг битүү мэдэрсэн байж таарах юм.

Хүмүүний оюун санаа бол гаднын мэдээллийг аваад аяндаа дотроосоо исэж дэврэхийн жишээг тэгж санагдуулнам. Орчлонгийн цэг бүрд шүглэсэн хумхи хар нүх буюу эрчлүүрийн үйлээр ухаарлын далд далай исэж аяндаа дэвэрснээс тэлэлт үүсэж байх мэт. Хүмүүний танин мэдэхүйн

мөн нэг тулгуур асуудал энэ болой.

Улаач- скаляр долгио. Амьдралын бараг алхам бүрд цахилгаан соронзон долгио нэвтэрчээ. Тархах чиглэлдээ зөвхөн хөндлөн Е болон Н векторын шүтэлцэн хувирах долгио гэж үзсээр ирэв. Хоёр цахилгаан соронзон долгионы гүвгэр, хотгор нь эсрэг таарахад усталцаж юу ч үгүй болно хэмээн төсөөлсөөр иржээ.

Гэтэл дурдсан хөндлөн долгио усталцахад үлдээд цааш орон зай руу ер бус энерги “юүлж”, тэгэхдээ бүр далд ертөнц рүү шингэдэг тууш догио байсныг саявтархан зөвшөөрөв. Сербийн инженер Никола Тесла [13] өнгөрсөн зууны эхний мөчид илрүүлснийг хэрэгсээгүй аж. Түүнийг скаляр долгио [2] гэж хэлдэг юм.

Скаляр долгио бол тэгэхлээр маний ертөнцөд илээр үгүй авч гайхам шид чанартай долгиолог энерги мөн. Тэр шидийг нь шинжлэх ухаан мэр сэр илрүүлж, эрдэмтэд шүүн ярилцаж байна. *Огторгуй* дотор гүйж тарахгүй, зогсонги учраас скаляр нэртэй болж. Огторгуйн цэг бүрд цахилгаан соронзон потенциал энерги эгшин зуур бүрэлдүүлнэ. Эгэлээр зүйрлэвэл савыг (орон зай) урсгал нь хугацааны туршид үелсэн хувирах төрөл төрлийн шингэнээр дүүргэх лүгээ төсөөтэй гэвэл ойролцоо очмоор юм шиг. Шингэнийг тоо хэмжээгээр нь тодорхойлно. Саван дахь шингэн нь огторгуйд тарж урсах вектор хэмжигдэхүүн бус савын хэмжээг дүүргэн цэг бүрд нь үелэн хувирна. Скаляр энерги бол давших цахилгаан соронзон долгионы бүх цэгт далд эрчлэл нягтралаар төрөл олж үүсээд “огторгуй савыг” дүүргэсэн, гурван цагийн (хугацааны туршид үелсэн) мэдээлэл энергийн (холограф-долгилог) “тунамал” хэмээн төсөөлж болмоор аж.

Мөнх Тэнгэр эрдмийн туршилтын суурь нь болдог бөө улаач нарын онгод үйлийг ил ба далд ертөнцийн хооронд мэдээлэл дамжуулж харилцахдаа скаляр долгио цацруулж бас хүлээн авдаг байж таарах л болов уу.

Шид чанар нь. Скаляр долгио биетийг тунгалаг (далд!) нэвтлэн орон зайг дүүргэх учир цэг бүрд нь шүглэж байршина. Аливаа юмс, оршихуйд бүрэлдэл, эд эс бүр нь скаляр долгионы хугацааных нь “дарамтад” өөрийн эрхгүй өртөх үйл тохионо. Мөнөөх юмсын дотоод амин хувирлын хурдыг нь өөрчлөх шид хүч үйлчилнэ.

Тэгэхлээр юмсын хугацааны амь жамыг хувиргах, тухайлбал, ухаан санаа, сэтгэлийн албадмал болон санамсаргүй хөдлөл, таталцлын орны хугацааны дэг горим, биеийн масс, инерцэд чанарт ч нөлөөлөх болно. Скаляр долгиог газрын гүнд “юүлбэл” цөмийг нь хайлуулж, цахилгаан соронзон долгионд хувиргаж болох юм. Ямар орчин байхаас хамаарахгүйгээр цаг цагийн мэдээллийг үелэн давхарлуулж “долгилог”

тунамал-холограф орон зай үүсгэдэг гэж үзэхэд хүргэж байна. Скаляр энерги газар дэлхий, тэнгис далай, Орчлонг ч эгшин зуур сааралтгүй дүүргэн дэгээд, мэдээллийг хоёр талд шууд дайж хүргэх шидтэй. Далдыг харах боломж олгоно. Үүнээс өлгөвөл, дэлхий тойронд үүсэх скаляр долгио болон скаляр гэрэл хүний ухаан санаанд нөлөөлнө. Хүнээс цацрах скаляр долгио нь санаа бодлыг нь байгалийн үзэгдлийг залахад нөлөөлж болох юм байна. Өмнө дурдсан туршилтын дүнг үүнийг нотолж байна гэмээр.

1. Эсийн барилдахуйн мэдээлэл

Эсийн мэдээлэл. Хүний цусны цагаан цогцсоос ДНХ-ийг ялгаж аваад, эзнээс нь хол өрөөнд байрлуулаад туршилт үйлджээ. Туршилтын явцад нөгөө хүнд ший үзүүлж, сэтгэлийг нь догдлуулахад үүссэн цахилгаан соронзон долгионы эрчмийн ихсэж, буурсан хувирал мөнөөх дээжийн цацруулсан мэдээллийн төрх хэлбэр хоёр цаг хугацааны хувьд яг давхацсан [14] байна.

Дээжийг хичнээн ч алсад байрлуулсан үр дүн нь адилхан, хугацааны өчүүхэн ч шилжилт гараагүй байна. Шинжээч Г. Бредэний өгүүлснээр бол амьд эс өөр хоорондоо эдүгээ хүртэл *танигдаагүй энергийн хаана ч үл саарах* орноор мэдээлэл дамжуулан харилцдаг аж.

Тэр энерги орон зай, хугацаа, орчинд өртөж хувирдаггүй, орон зайд хаа сайгүй орогнох боловч эвлэрэн багцарч амьсах шидтэй аж. Үйлчлэл нь орон зайг бүхэлд нь хамарсан хоморго дэнслэх (non-local) төрхтэй аж.

Хүмэнэй цацруулж, шингээж буй скаляр гэрэл нь ердийн гэрлээс эрс өөр амьд ертөнцийн хувирахуйн шинж мэдээллийг тээхээр зохицон бүрэлдсэн, шинэ төрх-биогэрлэн тун буюу биофотон юм гэж үзэж байна. Биофотон ердийн фотоноос илүү цогц “амилаг” нягтрал бүхий мэдээлэл хадгалдаг бөгөөд далд билиг ертөнц рүү хургах буюу бас тэндээс цацарч ил юмст шингэх аж. Чингэхүй ил хийгээд далд ертөнц биоскаляр долгионоор шүтэн барилдах заяатай аж.

Олон “өнгө” солонгорол бүхий давтамж нь дотоод нарийн бүтцэд дүйж, бас зуурдын олон хэмжээст огторгуйн үелсэн задгай “мушгиа” эрчсүүдэд харгалзах заяатай гэвэл зохимуу. Цогцостоо төдийгүй, орчинтой хаа сайгүй мэдээлэл солилцож торгон тохироот шийдвэр гаргах үйлийг жолоодоход ДНХ-ийн биофотонт цахилгаан соронзон орны мэдээлэл өртөөлөх үйл онцгой үүрэгтэй буюу.

Мэргэн увдист хүний эс, нейрон нь бусад хүний бие цогцостой билиг биофотонор харилцан нөлөөлдөг бололтой. Энэ мөн л шийдэл хүлээсэн асуудал мөн.

Гений донж. ДНХ-ийн 100 хос суурь бүхий нэг хуруу шилэнд өөр хуруу шилэнд цэвэр ус [15] хийжээ. Тэгээд мөнөөх хоёр дээжийг сулхан цахилгаан соронзон долгио цацруулж буй зэс ороомог дотор байрлуулан гаднын долгионы нөлөөнөөс хамгаалаад гадна нь ДНХ-тэй хуруу шил байрлуулжээ.

Хэдэн цагийн дараа ДНХ-ийн ямар нэгэн ул мөр шинээр үүссэнийг тодруулахаар мөнөөх хоёр дээжид энзим нэмж биохимийн гинжин урвал явах нөхцөл бүрдүүлжээ. Тэгтэл гайхалтай нь хоёр саванд хоёуланд нь ДНХ-ийн бүтэц илэрч. Угтаа нэгэнд нь цэвэр ус байсан шүү дээ. Туршилтыг үйлдсэн Монтагниэр ДНХ нь өвөрмөц цахилгаан соронзон долгио цацруулж усны молекулд ДНХ молекул бүрэлдүүлэх донж (code) мэдээлэл хадгалуулсан байна гэж үзжээ. Дээр өгүүлснийг санавал, усны молекулч гаднын мэдээллийг хүлээн авч хадгалаад, нөхцөл тохиоход Тэнгэрийн сэрэхүйн зарлиг шийтгүүлж, улмаар шинийг бүтээхэд үйлийг өртөөлөн дамжуулдаг шидтэй мэт байна.

Туршилтын баримтаас өлгөвөл, ДНХ нь бас алс зайд өөрийгөө төлжүүлэн хувилах гений донж жорыг өөр эс рүү дамжуулдаг байна. Гений донж бол удамшлыг газарт шууд жолоодох бэлэн жор дүрэм төдийхөн бус харин тухайн биологи бүтцийг шинээр бүрэлдүүлэх тэнгэрийн сэрэхүйн түгээмэл (далд) билиг орны зарлигийг “тухай бүрд” нь шийтгэж, зөв нөхцөл тохиоход бүтээн хэрэгжүүлж эхэлдэг гэмээр л байна. Тэгэхлээр Орчлон хэмээх ухаант “тархи” хаа нэгэнтэй үүссэн бодисын бүтэц, удамшил хийгээд ухаарал, сэрэхүйн донж мэдээллийг газар дэлхий дээр төдийгүй, нөхцөл зөөлөрч тохиосон тэнгэрийн алсын эрхэст хол ойроос хамаарахгүйгээр шууд дамжуулан бүрэлдүүлэх зарлиг гаргах шид хүчтэй байж болох нээ

Эс ба соронзон скаляр долгио. Эрдэмтэн Мэйлийн судалгаа квант физик, эсийн биологийн заагт эрдмийн шинэ мэдээ [16] илрүүлэв. Эсийн ДНХ нь “соронзон скаляр долгио” цацруулдаг болохыг илрүүлсэн байна. ДНХ-ийн цацруулж шингээдэг соронзон скаляр долгио бол эс хооронд болон хүрээлэн буй орчин мөн бусад хүний ДНХ лүгээ зайнаас резонанслаж (найран дарвиж) мэдээлэл солилцдог болохыг [17] эл туршилт илрүүлжээ.

Хүмэнэй бие багцаагаар 50 тэрбум эстэй бөгөөд зэрэгцүүлэн байрлуулбал дэлхийгээс нар хүртлэх зайнаас 400 дахин их болно гэсэн мэдээлэл ч бий. Өмнө дурдсан туршилтуудаар илрээд буй эсийн “билиг” шид чадварыг бодолцвол хүмэнэй бие цогцос нь дотоод ертөнц төдийгүй гадаад Орчлонгийн тоо томшгүй физик, биологи хувиралтай шүтэн барилддаг аж. Туршилтын

баримтаас үзэхүл, ДНХ-ийн биоцахилгаан, соронзон орон бол аргын эрдэм ухаанд ор үгүй чинад биофотон, скаляр долгионоор дамждаг болж таараад байна. Эцэст нь хэлэхэд биоскаляр долгионоор дээд оюун ухаант хүмэн, амьтан харилцдаг байна.

Бодисын цацруулж, шингээдэг скаляр долгионоос бүр ч эрс ялгаатай. Биоцахилгаан соронзон скаляр долгио (орон) нь ил ертөнцөд төрөл олж заяасан бидний сүнс сүлдний мэдээллийг чинад билиг сэрэхүйн Орчлонд дамжуулах шид тавилан бүхий орон-оршихуй мэт байна. Эсийн олон гайхамшигт шид чанарыг бас төнхөж болгоовол нэн олон ид чадлыг илчилсэн санаа тэрлэнэ. Эл шид чадлыг хүмэн эзэгнэх заяатай боловч дийлэнх нь газрын шуналт зовлон туулах амьдралын эрхшээлд автсанаас болж гэсэн бололтой.

II. Хойт нас. Сүнс

Амьсгал хурааж, зүрх, тархины үйл ажиллагаа зогссоноор амьдрал төгсдөггүй ухаарал, мэдрэхүйн үйлийг тээсэн сүнс мөнх орших тухай мэдээлэл дэлхийн эрдмийн хийгээд цахим өртөөгөөр дэгж тарах болов. Эдүгээ амь, сэрэхүй нь Орчлонгийн язгуур зүй жамыг танин мэдэхэд гогцоо ач холбогдолтойг газар сайгүй хэлэлцэж, эрдмийн нэрт төвүүдэд туршин судалсаар байна. Германы физикч болон эмч эрдэмтэд хамтран амьсгал хураасны дараа ч амь, сэрэхүйн шид чадвар цогцоос салж дангаар оршин байхыг эмнэлэхүйн (clinic) туршилтаар [18] нотолсноо зарлажээ.

Зүрх нь зогссоноос хойш 20 минутын дараа “үхлээс” эргэсэн хэдэн зуун хүмүүс дээр уг туршилтыг үйлджээ. Цогцсоосоо салж, хөөрч дэгдэж, тогтуун амгалан, айх зовох юмгүй, дөлгөөн байдалд орж, гэрэл гэгээ дүүрэн бялхсаныг мэдрч байсныг мөнөөх хүмүүс ижилхэн хэлдэг аж. Тийм туршилтыг дэлхийн хэд хэдэн лабораторид бас үйлджээ.

Чингэхүй, тархины үйл ажиллагаа зогсмогц сэрэхүй мэдрэмж дуусгавар болно хэмээсээр ирсэн шинжлэх ухааны бодист суурилсан номлол эргэлзээтэй нь тодорч, харин ч сүнс, цогцос хоёр тус тусдаа салж, дагнан оршиж болохыг тийнхүү туршилтаар харуулав. Эрдмийн галын тэргүүн Др.Экерман “манай үр дүн олон хүний үзэл үнэмшилд таашаал төрүүлэхгүй байх, гэхдээ бид хүмүүн төрөлхтний түүхнээ байсаар ирсэн нэг агуу асуудалд хариулт өгөв” гэсэн байна.

Туршилтаас ургуулж бодохуйд билиг сэрэхүй уураг тархи-бодисоос үүсэж бүрэлдэж байсан бол тархины ажиллагаа зогсмогц дагаж мөхөх л байсан шүү дээ. Тийм биш ажээ.

Тэнгэрийн сэрэхүйн орны төлөөний элч-сүнс мөхсөн цогцсоос хийлж, дангаар орших төлөвт ороод зүрх тархи амилмагц буцаж цогцос лугаа ний болдог аж.

Сүнс сэрэхүй бол тулгуур оршихуй буюу Орчлонгийн алив бодислог юмсыг ч бүрэлдүүлэх, амьжирч ухаарах үйлийн эх хөврөл нь болдог хэмээн төсөөлбөл болох мэт. Сүнсийг нягтлан шинжлэх нь хүмүүний өмнө тулгамдсан бас нэгэн гогцоо асуудал мөн.

Дээдсийн онгодуудтай хөөрөлдөв. Өвөг дээдсийн “мөнх” сүнстэй шууд харилцаж, хүмүүний соёлын гайхамшигт дурсгалын нэг “Монголын нууц товчооны” язгуур эхийг босголоо гэдгээ зайран, удган нар над дуулгасан юм.

Сүнс, цогцос тусгаар оршихуй болохыг дэлхийн эрдэмтэд нотлохоор ид чармайж байхад энэ мэдээ итгэх, эргэлзэхийн заагт намайг гайхшируулав. Тэгж онгод сүнснээс ном, эрдэм, түүхэн туршлага асууж туурвих боломжийг хэрэгжүүлсэн нь үнэн байх аваас шинжлэх ухаан өнөөдөр дээд тэнгэрийн элч-билиг сүнсний учрыг олохоор чармайж байхад өвөг дээдэс маань аль явир цагаас харилцаж далд соёл, эрдмээ бадраах нэг чухал ундарга болгож чадсан юм биш үү гэдэг бодолд эзэмдүүлэв. Миний эргэлзээг мэдэрсэн бололтой удган таныг дээдсийн онгодтой хөөрөлдүүлэе гэж урив.

Их эзэн Чингис хаантан “... Мөнх Тэнгэрт ивээгдэж, гүр улсыг зүтгүүлж...” байснаа давтан давтан хэлсэн, бас Да Будда багштан: “сүнс таны юм чинь биш, та бол тэр чигээрээ жинхэнэ сүнс...” хэмээн сургасныг энд лавшруулбал миний оюун ухаан бол дээд тэнгэрээс заяасан илч бөгөөд цогцос маань харин мөнхүү оюун ухааныг тээж яваа газрын амилсан, азтай атганхан шороо мэт аж. Чингэвээс миний гэх юм бол зөвхөн дээд тэнгэрийн билиг заяа, газар дахь мэдрэхүйн сүлэлдлээр бүрэлдэж буй бодол санаа л юм.

Бодол бүхнийг бүтээх чадалтай. Баримт нь хүмүүний соёл, иргэншлийн дэвшил мөн. Санаа хар бол чөтгөр тал руугаа хазайна.

“Дээд тэнгэрээс заяат” төрсөн нүүдэлчид арга эрдэмд төдий л суралцсан бус харин бөө тархиар Орчлонгийн сүнс далай лугаа дэнслэн хоморголж ний болохуйд Мөнх Тэнгэрийн хүчний жолоонд бултаараа атгуулан тэнгэрийн “нэгэн” хүнд багцарч омог үндсээрээ тэнгэр-газар-бие-сэтгэлийн үл бутрах, үл урвах, ямагт ялан дийлэх найраг шид чадал [2] олсныг суут түүхэн үйл явдлын баримт хэдийнээ баталчихсан бус уу хэмээн бодсоор хөөрөлдөөнд оров. Улаач эмэгтэй олон омгийн дээдсийн сүнстэй, нэг л өөр аялгуугаар ярьж хөөрөлдүүлэв.

Ярианы учир язгуураас үзэхүл улаачийн

үг биш нь тодорхой байлаа. Таны онгод улаачийн биеийг эзэгнэн ярьж байна уу гэвэл тийм гэлээ. Та улаачийн цогцсыг хир удаан эзэлж чадах вэ гэвэл, энэ хүний сүнс миний хажууд байна, их удаж болохгүй бие, сүнс нь холдож үжирнэ гэж байлаа.

Нууц товчоог хэн санаачилж бичүүлсэн болоо гэсэн асуултад хариулах онгодыг дуудах болов. Тэгж байтал “би Шихихутаг байна” гээд ярилаа. Үгийг багцаалан сэргээвэл: их хаадаас Мөнх Тэнгэрийн хүч зарлигийг сахиж төр улсын босоо голч засаг, цааз, ёсыг цэгцрүүлсэн гайхамшигт дэг жаягийг мөнхжүүлж, өвөг дээдсийн тогтоож хэрэгжүүлсэн хууль, жамыг төр, эх оронд зүтгэх хэн боловч үеийн үед чанд мөрдөж, хэзээ ямагт тэнгэрийн зарлигаас буцаж няцах, урван тэрслэх, бузрыг үл тэвчих чин бат нягт зорилго, тэвчээртэй яваасай хэмээн хүсээд тэр цагт байсан мэргэдийн төлөг хэллэгийг эмхлэн түүхэд суурилуулан эл судрыг бүтээлгэх саналыг би гаргасан юм гэлээ.

Сүнс бол дээд тэнгэрээс заяат хүмэнэй сүлд “эзэн” нь юм. Жинхэнэ хүмэн бол тэгэхлээр газрын амьтан бус хүсэл, залбирлаар аливааг бүтээх шид бүхий дээд тэнгэрийн “шид чадлыг” ариун эзэмдсэн заяатан [19] ажээ. Зөв хүсэл мөрөөдлөө бүтээх тэнгэрлэг, бурханлаг заяатайгаа та гүнээ мэдэрч сүнсээ ариун дээдэд залж, шунал, сэтгэлийн бузраас салангад байж, хүмүүний сайн сайхны төлөө зүтгэх нь Орчлонгийн хувьсахуйн “зул-цэцэг” -хүмэнэй эрхэм зорилго мөн.

III. Тэнгэрийн сэрэхүйн хүчний орон

Тэнгэрийн сэрэхүйн орон болон хүчний тухай шинэ таамнал [3] энд дэвшүүлэв. Өмнө дурдсан туршилтын баримт, онолын цэгнэлтээс ургуулбал миний дассан орон зай-3D огторгуй, хугацааны хил хязгаарын чинад гүн тийш няргаж, ил хийгээд далд ертөнц дэх аливаа үйлийг бүхэлд нь шүтэлцүүлэн жолоодох тэнгэрийн сэрэхүйн хүч буюу ухаалаг орон-билиг залуур буюу маний хэлж дассанаар “тархи” байна гэх санаанд [3, 2.Б1.9] хүргэж байна. Түүнийг энд тэнгэрийн сэрэхүйн орны буюу тэнгэрийн сэрэхүйн хүч хэмээн нэрлэв.

Сиергетикийн үзлийн өндөрлөгөөс үзвэл Орчлонгийн хувьсал нь оройн дээд төвшиндөө “бурханлаг” бүхний тавиланг шийтгэж өрнүүлэх билиг хүчийг шууд төрүүлнэ. Их суу залийн жолоодлогоор ямагт төгөлдрийг бүтээж дэвшсээр бүхнийг бүрэлдүүлэх, бүрэлгэх түгээмэл шид зүйг урлажээ.

Өмнө бүтээсэн болон шийдсэн бүхнийг төгөлдөржүүлэхийн хамт шинийг бүтээх энерги-мэдээлэл бүхий тэнгэрийн сэрэхүйн хүч (зарлиг)-ийг үүсгэх заяаг тэгж дархалжээ. Тэнгэрийн сэрэхүйн орныг амьгүй болон амьтай бодис

бүрэлдэлт юмсын хувьслын дүнд үүсэх бүтэц хийгээд билиг сүнслэг төөргийг ч бүтээх зарлиг шийтгүүр “хүч” хэмээн төсөөлнөм.

Тэнгэрийн сэрэхүйн хүчний орон лугаа онгод совингоор ний болоод билиг эрдэм, соёлыг бадруулах нууцыг олоод бүр өөд болсон өвөг дээдсийн сүнс лүгээ харилцаж сургамж авах шид удисыг монгол нүүдэлчид эзэмдсэн байж. Өгүүлснийг оньс нь одоо ч олдоогүй тэгсэн мөртөө ул мөр нь улам бүр дурайх нүүдлийн далд ундаргад соёл, удаа дараа их талд их гүрнүүдийн мандан тогтносон түүхэн туршилт гэрчилнэ [2.Б] гэдэгт үл эргэлзнэм. Нүүдэлч үндэстэн тэнгэрийн сэрэхүйн хүч лүгээ бултаараа нийлэн найраад тэнгэрийн нэгэн хүмэн болж цэгцэрчээ. Тэнгэрийн “хүн” нь тэнгэрийн сэрэхүйн хүчний орон лугаа ний шид заяаг эдэлснээр үл няцах, үл дийлдэх ид хавыг олж, түүхэн сод үйлийг бүтээжээ. Тэгэхлээр нүүдэлчид дээд тэнгэрийн билиг удист эв хүчээр газрын дэг бүхий цэргийн олон хүн, хүчтэй тулалдаж байсан аж.

Дээр танилцсан туршилтуудыг тойруулан санаа төлжүүлж ярилцсанаас үзэхүл, хүн бол яахын аргагүй мөнөөх Орчлонгийн билиг далайн дусал буюу бүх мэдээллийг өвөрлөсөн Тэнгэрийн сэрэхүйн хүчийг тээсэн, “дээд” заяат элч ажээ. Тиймээс амьсгалаар жолоодон сэтгэлийн гүн төвлөрөлд хүрвээс өөрийн билиг далай лугаа ний болно.

Хүмэн бол дээд оюун ухаант-“бурханлаг” шидийг тэгж өвөрлөсөн болохоор Орчлонгийн “хар” билиг холограф далайн хэлтэрхий лүгээ нэвтрэхүйд, 3 цагийн мөнхийн мэдээллээс оюун сэрэхүйдээ буулгаж, улаачлан мэдээлэх чадавхтай. Долгиолог төрх ноёлсон далд далай-билиг холограф сангаас мэдээллийг хүмэн тийнхүү олзлох шидтэй юм. Тэгвэл хүмэн бол далд далай лугаа тэгж ний болсноор Орчлон лугаа нэгэн цул-амьд багцрах заяатай аж.

Тэнгэрийн сэрэхүйн хүч. Байгальд таталцал, цахилгаан соронзон, цөмийн болон сул хүчний үйлчлэлээр алив бодист оршихуй бүрэлдэх, бүрлэхүйн мөнхийн тавилан туулна. Алив юмс бүрэлдэх, орших, хувирахуйн тэнгэрийн зарлиг-жам тийнхүү ил Орчлонд эдгээр тулгуур хүчний үйлчлэлээр хэрэгжих нь тов тодорхой. Шинжлэх ухаан тэрхүү жамаас илрүүлснээ “нээлт” хэмээж, хууль болгож тунхагладаг зуршилтай. Улмаар ашиглах аргыг олж технологи бүтээгээд, дэвшлийг хөтөлсөөр ирж.

Цэг бүрд эл дөрвөн тулгуур хүчийг ухаалгаар зохицуулж, Орчлонгийн цул амьсахуйн хувьслыг нэгэн жолоонд “атгаж” хэрэгжүүлэх үйлийг шийтгэж хөтөлдөг тэнгэрийн сэрэхүйн хүч байгааг тийнхүү зөгнөж байна. Эл 4 хүчийг Орчлон даяар хаа сайгүй гагцхүү тэнгэрийн сэрэхүйн хүч

жолоодно гэх санааг энд тийнхүү дэвшүүлэв. Бидний дассан механик төрхт хүч бус харин алив хувирал үйлийг хөтлөх “тэнгэрийн зарлиг”, шийдлийг эрхлэн хөтөлдөг сэрэхүйн билиг-энерги чадавх хэмээж буйг дахин болгомуу.

Өмнө дурдсан билиг (холограф) ертөнц бол тэнгэрийн сэрэхүйн зарлиг шийтгэж аливаа хувьслыг энэхүү дөрвөн хүчээр гүйцэтгүүлдэг сэрэхүйн билиг орон хэмээн төсөөлж байна. Хүмэн ч ялгаагүй эхлээд хийж бүтээх шийдэл боловсруулаад мөнөөх л хүчнүүдийн цогц нь болох хүч, техникээр хэрэгжүүлдэг шүү дээ. Хүмэн ч мөн тэр шидэт орон холографийг тээсэн бодисын “хэлтэрхий” нь мөнийг энд давтан саная.

Дэлхийн түмний олон шашин мөргөл нь тэр далд оронд булхсан одод ертөнцөөс Орчлонгийн билиг шид хүчийг [20] ямар нэг байдлаар мэдэрч, тэмтэрч байсан нь гарцаагүй.

Тиймээс хүмэн залбирал, тарни, шүтлэг, бясалгалаар тэнгэрийн сэрэхүйн хүчний орон лугаа ний болохуйд гэгээн шидийг олох увдистай. Орчлонгийн холодалай лугаа мөнөөх хүмэн-билиг холодусал ний болоход илийн хууль бүрэн алдарч Орчлонгийн мөнхийн оршихуйг гагцхүү тэнгэрийн сэрэхүйгээр мэдэрнэ. Энэ бол Будда багшийн анх мэдэрч томьёолсон “хоосон чанар” гэлтэй.

Ер нь бурхан хэмээх ид шидэт “хүнлэг” төрхтөн тэнгэрт байхгүй, чөтгөр ч байхгүй гэдэгт итгэнэм. Харин Орчлонгийн хувьслын оройн дээд гарц бүтээгдэхүүн бол Тэнгэрийн сэрэхүйн хүчний орон буюу аливаа хувирлыг гүйцэтгэх “зарлиг” шууд шийтгээд бас үйлсийг нь хэрэгжүүлэх тулгуур хүчний орон бүхий ухаарал сэрэхүйн эрч хүч гэж төсөөлснөө давтан хэлье.

Орчлонгийн дээд оюун ухааныг эзэгнэсэн хүмэн бол тэрхүү тэнгэрийн сэрэхүйн орны шид хүчийг бүрэн өвөрлөсөн тэнгэрлэг хэлтэрхий нь болохыг ч бас санах нь зүйтэй буюу.

Чингэхүй хүмэн бол Тэнгэрийн сэрэхүйн хүчний орон лугаа амьсахуйд аливааг бүтээх, бүрэлгэх зарлиг шийтгүүлэх шид өсгөвөр-хөрөнгө тээж төрсөн дээд заяатан юм байна. Хүний залбирал бас ургамал, амьтанд тохиож буй физик, хими, биологийн хувирлын мэдээлэл ч тэнгэрийн сэрэхүйн орны зарлиг дагуу хэрэгжих магадлалтай аж. Хүмэн (хувилгаан?) итгэл үнэмшилдээ суурилсан залбирлыг дуу хоолой болон оюундаа бясалгахдаа ургуулан товлосон зураглал, хүсэл төсөөлөлт бодлоо давтан давтан үйлдэхэд төв мэдрэлийн систем дэх зураглалт мэдээлэл нь тархины цахилгаан соронзон мэдээллийг үүсгэнэ. Сүүлчийн мэдээлэл нь зүрхний цахилгаан соронзон орны хувирлыг өдөөж чангараад улмаар цусны урсгалаар бүх бие, цогцост хүрнэ. Шинжлэх ухааны өнөөгийн цэгнэлт ёсоор зүрхний цахилгаан соронзон орон тархиныхаас 100000

дахин хүчтэй аж. Бодис болон ДНХ нь илийн чинадад өөр хоорондоо болон далд орчлонтой цахилгаан соронзон скаляр долгионоор харилцдаг байх магадлалтайг туршилтын баримт [15,15,17] харуулжээ.

Биес цогцсын эд эс дэх ДНХ, нейрон бүр нь тэр мэдээллийг аваад, скаляр долгион үүсгэн дарвиж харилцахын сацуу далд билиг ертөнцөд зохих мэдээ “саналыг” нэвтрүүлж бас хүлээн авдаг мэт. Ургамал, амьтны хувьд ч газар дахь амьдралын нөхцөл хувирлын мэдээлэл мөн л скаляр долгио болон тэнгэрийн сэрэхүйн орны төвд нийлдэг байх.

Мөнөөх мэдээлэл тэнгэрийн сэрэхүйн хүчний орноо боловсроод шийдвэр зарлиг нь скаляр долгионоор бүхий л юмст төвшин зэрэглэл, эрэмбээр хүрч газрын амьгүй юмсын бүтэц, амьтай юмсын удамшлын түгээмэл зүй тогтлыг жолоодох хөтлүүр донж нь болно хэмээн төсөөлнөм.

Дашрамд хэлэхэд, *байгалийн* шалгарлаар амьд юмсын төрөл зүйл дэлхий дээр үүссэн гэх Дарвины номлол нь газар-ахуйд уяатай хөтөч үзлийн хүрээнд боловсорчээ. Харин газар дэлхий болон билиг ертөнцийн хооронд мэдээлэл солилцон шүтэлцсэний үрээр *тэнгэрийн сэрэхүйн хүчний зарлигаар* газарт амь заяатай төрөл зүйлийн төвшин бүрд хэрэгжих төөрөг бүхий удамшлын түгээмэл донжийг амьд ертөнцөд бүрэлдүүлсэн байна. Энд хэлж буй санаануудыг өмнөх сондгой ёр туршилтуудаас үрслүүлснийг болгомуу. Тэгж хүн тэнгэрийн сэрэхүйн хүчний бүтээхүйн үйлд амьсан нэгдэх дээд заяа түшсэний ачаар бодол хүслээ хэрэгжүүлэх шидтэй аж.

Гэвч богино бодол, ханахгүй шунал, сэтгэлийн бузардалд, атаархал, залхууралд хөтлөгдөн ахуй, хар амиа бодож, хөлгүй “зовлон” туулж амьдарснаар тэр шид чадлаа бараг бултаар нь гэссэн байгааг санах нь зүйтэй буюу.

Харин хар муу бодлоос ямагт зайлсхийж хүсэл мөрөөдлийг ариун байлгах нь дээд тэнгэрийн эрхэм жам ажээ.

Нууц товчоонд “дээд тэнгэрээс” заяат удмынхан тийм увдистай байсныг нууц товчоонд [21] товойлгон өгүүлсэн байна.

Чингис хааны суут үйлс бол тэрээр бат итгэж бүрэлдүүлсэн зорилгоосоо үрслүүлсэн мөрөөдлийн “уулыг” тэнгэрийн сэрэхүйн хүчний орон лугаа хөрөнгө-хөврөл болгон дарвиулснаар уг үйлийг бүтээх шийд шийтгүүлээд, улмаар хэрэгжүүлэх билиг ур, эв дүйг чадварлаг хөтөлж байсанд оршино.

Дээд тэнгэрийн заяа түшиж, билиг буюу тэнгэрийн сэрэхүйн бүтээх, хөтлөхийн ид чадал лугаа ний болоогүй аваас хэн ч бай газарт зовлон туулах амьдралд эргэлдэх болно.

IV. Мөнх Тэнгэрийн хүч

Өнөөг хүртэл нууц нь олдоогүй, ул мөр нь бүдгэрээгүй, цуурай нь сонссоор буй их талын нүүдэлчний соёл цэцэглэж, их эзэнт гүрнүүд бүрэлдсэний ундарга хүч нь чухамдаа чинад билиг эрдэм, дээд тэнгэрийн алив үйлийг хөтлөх ухаалаг заяаг түшсэнд оршиж байна хэмээв. Бодист юмст дархлаатай өрнийн шинжлэх ухаан яаж ч судлаад далд холограф далайн билиг ундаргад хүрэх сачий үгүй [1,3] байсан нь тийнхүү тодорч байна.

Хүннү, Сүннүгийн үеэс чинад билиг ундаргатай эрдэм, соёл цэцэглэсэнд бат итгэнэм. Дээр өгүүлснийг эргэн нэхвээс, хүмэн тэнгэрийн сэрэхүйн хүчний орон лугаа амьсаад газар дахь хүсэл мөрөөдлөө залбиран илэрхийлэхэд, дээд тэнгэрийн билиг далайд тэр нь үйлс бүтээх билиг хөрөнгө болоод аяндаа “исэж” хэрэгжих ид хавыг бүрэлдүүлэх шид чадлыг олдог буюу. Их талын нүүдэлчид Мөнх Тэнгэрийн хүчийг тэгж өнө эртнээс эзэмдэх дадал чадвар эрчийг олсон байж. Дэлхий тойронд тийм шид хүч, тухайлбал өмнө ярилцсан скаляр долгионы эрч чадлыг эзэгнэж шийдсэн болов уу гэхээр гайхалтай ул мөр, баримт цөөнгүй байгааг санавал зохимуу.

Нүүдэлчдийг сургууль, эрдмийн төвгүй зэрлэг мэтээр тодорхойлж байсан нь ор үндэсгүй хэмээнэм. Харин ч эдүгээ хүмүүн алгуур мацан чиглэж яваа билиг эрдмийн тодорхой өндөрлөгт нүүдэлчид түрүүлж хүрээд, соёл бадрааж, зэр зэвсгийн хүч, цэргийн тооны давуугаар бус тэнгэрийн билиг сэрэхүйн хүчний яруу найрлын эрчээр сөрөг хүчийг ялан дийлж байсан мэт байна.

Өргөн цар хүрээтэй явуулдаг бөө зайран, удганы буулт, уул ус, тэнгэрийг хүндлэн тайх ёсон, тулааны өмнө хар сүлд тайж тахих зэрэг нь бүх нийтийг хамарсан билиг эрдмийн их сургалт [22] бас дадлага ч байж.

Тэнгэрийн сэрэхүйн орон түших заяатай амьдралд сургах, суралцах үйлс ч мөн л нүүх-суух үйлс дунд хэрэгждэг жамтай аж. Тэгснээр Мөнх Тэнгэр эрдмийн билиг мэдрэмж нүүдэлч үндэстнийг өвч хамран ихэнх хүн зонд тэнгэрийн билиг мэдрэмж, эрч хүч өгчээ.

Чингэхүй үндэстэн бүхлээрээ мөнөөх сэрэхүйн хүчний орон лугаа найраад тэнгэрийн “нэгэн хүнд” цэгцрэн нягтарчээ. Тэнгэрийн нэг “хүнд” тэгж цогцолсон нүүдэлчдэд дээд “тэнгэрийн төөрөг-тангараг” тохиосон болохоор үл няцах, үл урван тэрслэх, үл дийлдэх ид хавыг олжээ.

Тийнхүү нүүдэлчид ашиг сонирхлоо хуваалцах бүлэглэлүүдийн “аминч” зөвшилцөл болон харгис хүчээр дарангуйлдаг, шорон гяндантай төр бус харин Орчлонгийн жамыг чандлан дагасан Мөнх Тэнгэрийн зарлигт төрийг

байгуулсан аж. Тэнгэрийн зарлигийг сахин дээдлэх нь нүүдэлчдийн төр, нийгмийн ариун тангараг байжээ.

Дүгнэлт

Эл өгүүллэгт эртний монгол угсаат нүүдэлчид их талд төр улсыг байгуулаад Евро-Азийн хуурай газрын ихэнхийг эзэгнэсэн эзэнт гүрэн удаа дараа байгуулсны танихуй хийгээд соёл иргэншлийн жинхэнэ ундарга нь юу болохын учиг үзүүрийг физик болон хувьсахуйн санааг өнөөгийн өндөрлөг рүү хөтөлсөн квант физик хийгээд синергетикийн охь үзэл мөн эдүгээ тайлал нь олдохгүй байгаа ёр туршилтуудын баримтаас үүтгэн хайх зорилт тавьсан юм.

Туршилтын баримтаас ургуулбал, орчлонгийн 96 хувь нь далд оршихуй бөгөөд энэ нь угтаа ухаарал, сэрэхүйн энергийн далай буюу өвөг монголчуудын итгэж байсан Дээд Тэнгэр лүгээ дүйх буюу. Хүмэн бол орчлонгийн хувьслын оройн дээд мандал-оюуны далайн шид чадлыг бодист цогцостоо агуулсан “бурханлаг” увдис шидтэй аж. Хүмүүн газарт “зовлон” туулахдаа тэр чадлыг гээжээ.

Харин их талын нүүдэлч монголчууд Дээд Тэнгэрийн заяаг хамгийн түрүүн түшиж, билиг эрдэм-Мөнх Тэнгэрийг эзэмшээд тэнгэрийн нэгэн хүмэнд нягтарч, нүүдлийн соёл, иргэншил бадраагаад, улмаар дэлхий-нийгэм-хүнийг өвч өвөрлөсөн тэнгэрийн засаг тогтоох их зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж байжээ.

Амьдралын өлгий-Дэлхий ээжийг мөхөөчихгүй бол хүмүүнд тэнгэрийн засаг тохиох цаг гарцаагүй ирнэ гэдэгт итгэнэм.

Талархал

Энэхүү илтгэл “өнчрөөд” байхад зориг гаргаж, Монголч эрдэмтний дэлхийн XV их хуралд толилуулах боломж олгосон академич Ш. Бира, профессор, Ц. Ишдорж нарт талархал илэрхийлье. Матери анхдагч хэмээх номлолд автаж явахад минь дээд тэнгэрээс заяат гэгээнтэн, билиг танхай Ш.Лувсанвандан багштан “томьёонд” уяатай “балчир” байгальчийг тоож, квант физикийн шүтэн гүйцээхүйн зарчмыг монгол хэлний авиа сүлэлдэн хувирах зүйд хэрэглэх санаагаа дуулгаж, ном хаялцсанаар надад билиг ухаанд зүтгэх эрч тэмүүлэл асаасныг дурсан мөргөхийн сацуу, их билигтний сод санаа холдооч бадрах заяатайг болгоож явахыг эрх мэдэл тохиосон хэл шинжээч Пүрэвжав эрдэмтэнд захисуу.

Ашигласан материал

A. G. Manning, R. I. Khakimov, R. G. Dall A. G. Truscott, Nature Physics 11,539–542,(2015).

- Alain, Aspect. (1982). Philippe Grangier; Gérard Roger. "Experimental Realization of Einstein-Podolsky-Rosen-Bohm Gedankenexperiment: A New Violation of Bell's Inequalities", Phys. Rev. Lett., 49 (2): 91.
- Bohm, D. (1980). *Wholeness and the Implicate Order*. New York: Routledge & Kegan Paul
- Bohm, D., Hiley, B.J. (1993). *The Undivided Universe*. New York: Routledge and Kegan Paul
- Bryan E, Penrose. (2011). The Power of Stars, *Springer* Dean Radin et.al, Physics Essays 25, 2
- Банзаров, Д. (1997). Черная вера или шаманизм у бурят-монголов. Улан-Удэ
- Гумилев, Л.Н. (1992). В поисках вымышленного царства. стр. 4, 6. Москва
- Гумилев, Л.Н., Куркчи, А.И. (1994). Черная легенда. Москва: Экспресс
- Лхагва, О. (2011). Хумхи ертөнцийн квант жам. Улаанбаатар: Admon
- Лхагва, О. (2013). Орчлон, Суу заль, Мөнх Тэнгэр. Улаанбаатар: Битпресс
- Лхагва, О. (2014). Дэм үг, санаа, бодол, Монголын товчоон түүхийн тайлал номын, I, II бүлэг, х.10-15, Тэнгэр, Монгол, Газар
- Лхагва, О. (2016) Тэнгэрийн сэрэхүй ба билиг төөрөг I, II. Онолын сэтгүүл 1(004), х. 83, 92. Улаанбаатар
- Лхагва, О., Батмөнх, М. (2010). Молекул-нанобөөмийн квант лаборатор. Улаанбаатар: Битпресс
- Чоймаа, Ш. (2005). Монголын нууц товчоо, сонгомол эх. I бүлэг. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- http://pesn.com/2011/03/26/9501797_Teslas_Scalar_Waves_Replicated.
- <http://vaticproject.blogspot.com/2013/08/can-our-dna-electromagnetically-teleport.html>.
- http://www.Ay127_Contents.ppt/The Contents of the Universe.
- <http://www.newssum.com/german-scientists-prove-life-death-4038>.
- http://www.nobelprize.org/nobel_prizes/physics/laureates/2011.
- <http://www.redicecreations.com/specialreports/gbraden2.html>.http://www.scientificexploration.org/journal/jse_15_2_meyl.pdf.
- Journal of Cell Communications and Signaling, 2012;6(1):53–58. <http://www.meyl.eu>
- Pribram, K.H (1991). Brain and Percetion: Holonomy and Structure in Figural Processing. New Jersey: Hillsdale <http://www.atlanteanconspiracy.com/2013/02/our-holographic-brains.html>